

“Монголын Палеонтологи” сэтгүүлд өгүүлэл бэлдэх зааварчилгаа

Хяналттай өгүүллийн төрлүүд

- Эрдэм шинжилгээний өгүүлэл
- Эрдэм шинжилгээний богино хэмжээний өгүүлэл
- Тойм өгүүлэл
- Судалгааны мэдээлэл

Өгүүллийн урт, зориулалт (мэргэжлийн, энгийн, мэдээллийн г.м.) зэргийг үндэслэн өгүүллийн төрлөө сонгоно уу.

Илгээгдсэн өгүүллүүд тухайн сэдвийн хүрээнд мэргэжлийн хяналтаар орно. Хяналтыг 2-3 хөндлөнгийн шүүгч хянана. Төрөлх хэл нь англи биш судлаачид өгүүллээ сэтгүүлийн үндсэн шаардлагад нийцүүлэн илгээхийн тулд урьдчилан англи хэлний дүрэм, өгүүлбэрзүйг хянуулсны дараа редакцад илгээх шаардлагатай.

Бичвэрийг илгээх

Бичвэр нь өмнө нь хэвлэгдэж байсан, өөр сэтгүүлд хяналтад илгээгдээгүй эсхүл хэвлэгдэхээр зөвшөөрөгдсөн байж болохгүй. Бичвэрийг нэр дурдагдсан зохиогч нар санал нэгтэй дэмжиж, зөвшөөрсөн байх шаардлагатай. “Монголын Палеонтологи” сэтгүүл (МПС) нь хэвлэгдсэн материалтай холбоотой ямар нэг цалин, төлбөр зэргийг хариуцахгүй.

Зөвшөөрөл

Бичвэрийн нэг хэсэг болсон текст, зураг, график, хүснэгт нь өмнө нь хэвлэгдсэн материалаас ашиглагдсан бол зохиогчийн эрхийг эзэмшигч (хэвлэлийн байгууллага, зохиогч)-ээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авсан байх ба өгүүллийг илгээхдээ хавсаргавал зохино. Хэрэв ямар нэг зөвшөөрлийн баталгааг хамт илгээгүй тохиолдолд тус зураг, хүснэгт зэргийг өгүүллийн зохиогч өөрөө хийсэн байна гэж үзнэ.

Гарчгийн нүүр

Тус нүүр нь дараах зүйлсийг агуулсан байна. Үүнд:

- Зохиогч нарын нэрс
- Өгүүллийн товч, тодорхой, ойлгомжтой гарчиг
 - Гарчигт товчилсон нэрсийг ашиглахаас зайсхийх шаардлагатай
 - Орон нутгийн чанартай судалгаанд газар нутгийн байршлын нэрийг оруулна
- Зохиогч нарын харьяалал
- Өгүүллийн хариуцаж буй зохиогчийн и-мэйл хаяг

Хураангуй

Хураангуйг 200 үгэнд багтаан бичнэ. Хураангуйд эшлэл, хүснэгт, зураг, дэд гарчиг зэргийг оруулахгүй бөгөөд догол мөр авахгүй үргэлжлүүлэн бичнэ.

Түлхүүр үг

Түлхүүр үг нь тус судалгааг төлөөлөх 2-8 үгсээс бүрдэнэ.

Бичвэрийн формат

Бичвэрийг Microsoft WORD-ийн DOC, DOCX форматаар хадгалан бэлдэнэ.

- Бичвэрийг ARIAL фонт ашиглан, 11pt өндөртэй бичнэ.
- Онцгойлон тодотгох үгсийг ташуугаар буюу italic бичнэ
- Хуудсыг автоматаар, баруун доод буланд дугаарлана
- Бичвэр WORD-ийн FIELD функцийг ашиглаж болохгүй (эшлэл зохион байгуулагчийн FIELD кодыг бичвэрийг илгээхийн өмнө устгах шаардлагатай)
- Догол мөрийг TAB товчоор авна. SPACE BAR ашиглан догол мөр авахгүй.
- Хүснэгт хийхдээ WORD-ийн Table функцийг ашиглах ба SPREADSHEET-р оруулж болохгүй.
- Томьёог WORD-н EQUATION EDITOR эсхүл MathType-ийг ашиглан оруулна.
 - Математикийн үйлдэл зэргийг LaTeX ашиглан оруулж болно.

Товчлол

Нэршил болон үгсийн товчлолыг хамгийн эхний тохиолдолд дэлгэрэнгүй тодорхойлох ба хаалтанд товчилсон үсгийг бичнэ.

Талархал

Талархалд хүмүүс болон байгууллагын нэрс, тэтгэлэг, грант, судалгааг санхүүжүүлэгч зэргийг тоочиж тусад нь хуудсанд бичнэ. Санхүүжүүлэгч байгууллагын нэрийг бүтнээр нь бичнэ.

Ашигласан материал

Эшлэл

Бичвэрт эшлэлийг нэр болон оныг хаалтад бичнэ. Жишээлбэл:

- Үлэг гүрвэлийн тулгуур мөчийг бүрдүүлэгч яснууд нь харилцан адилгүй хөгждөг (Horner et al., 1999).
- Монгол оронд тархалттай хожуу цэрдийн хурдсууд нь орчин цагийн Калахари цөлтэй олон шинжээрээ төстэй (Jerzykiewicz, 1998).
- Хожуу цэрдийн махан идэшт үлэг гүрвэл *Tyrannosaurus rex* нь 10 орчим насандаа есөлтийн дээд хэмжээндээ хүрдэг болохыг Horner, Padian (2004) нар анх тодорхойлогджээ.
- Эрдэмтэд 1800-аад оноос эхлэн эртний тетраподын ясны микро бүтцийг судалжээ (de Ricqlès, 1968, 1972, 1974a, 1974b, 1974c, 1975; Enlow and Brown, 1956, 1957, 1958; Gross, 1934; Mantell, 1850; Nopcsa, 1933; Seitz, 1907).

Ашигласан материалын жагсаалт

Зөвхөн хэвлэгдсэн бүтээлүүдийг жагсаана. Хэвлэгдээгүй материалууд болон ам мэдээлэл зэргийг зөвхөн бичвэрт дурьдана.

Жагсаалтыг нэрсийн эхний үсгээр, цагаан толгойн дараалал, хэвлэгдсэн оноор жагсаана. Кирилл болон бусад хэл дээрх бүтээлийн зохиогчийн нэрс болон гарчгийг латинаар галиглан дурьдах ба дөрвөлжин хаалтанд ([]) гарчгийн орчуулгыг бичнэ. Нэг зохиогчийн тухайн ондоо гарсан бүтээлүүдийг латин a, b, c... гэх мэт ялган жагсаана.

- *Эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдсэн өгүүлэл*

Horner, J. R., A. de Ricqlès, and K. Padian. 2000. Long bone histology of the hadrosaurid dinosaur *Maiasaura peeblesorum*: growth dynamics and physiology based on an ontogenetic series of skeletal elements. *Journal of Vertebrate Paleontology* 20: 115-129.

Өгүүлэлд оролцсон зохиогч нарын нэрсийг бүгдийг дурьдах боловч хэт олон тооны зохиогчтой тохиолдолд эхний гурван зохиогчийг дурьдаад et al гэж товчилж болно. Жишээлбэл:

Pena, S.D.J., Pietro, G. D., Fuchshuber-Moraes, M. et al. 2011. The Genomic Ancestry of Individuals from Different Geographical Regions of Brazil Is More Uniform Than Expected. *PLoS One* 6: e17063.

- *Ном болон зэрэг горилсон бүтээлүүд*

Vrba, E. S., and G. B. Schaller (eds.). 2000. *Antelopes, Deer, and Relatives: Fossil Record, Behavioral Ecology, Systematics, and Conservation*. Yale University Press, New Haven, Connecticut, 341 pp.

Schatzinger, R. A. 1975. Later Eocene (Uintan) lizards from the greater San Diego area, California. M.Sc. thesis, San Diego State University, San Diego, California, 212 pp.

Saysette, J. E. 1999. Postcranial estimators of body mass in pecorans with emphasis on Capromeryx (Mammalia: Artiodactyla). Ph.D. dissertation, Colorado State University, Fort Collins, Colorado, 192 pp.

- *Номын бүлгүүд*

Emry, R. J., P. R. Bjork, and L. S. Russell. 1987. The Chadronian, Orellan, and Whitneyan North American Land Mammal Ages; pp. 118–152 in M. O. Woodburne (ed.), *Cenozoic Mammals of North America*. University of California Press, Berkeley, California.

Emslie, S. D., and N. J. Czaplewski. 1999. Two new fossil eagles from the late Pliocene (late Blancan) of Florida and Arizona and their biogeographic implications; pp. 185–198 in S. L. Olson (ed.), *Avian Paleontology at the Close of the 20th Century: Proceedings of the 4th International Meeting of the Society of Avian Paleontology and Evolution*, Washington, D.C., 4–7 June 1996. *Smithsonian Contributions to Paleobiology* 89.

- *Хэвлэгдэж буй өгүүллүүд*

Zhang, J.-Y. In press. New fossil osteoglossomorph from Ningxia, China. *Journal of Vertebrate Paleontology*.

- *Эрдэм шинжилгээний хурлын хураангуй (хэвлэгдсэн)*

Nydam, R. L. 2002. Advances in our understanding of the polyglyphanodontine lizards of North America. *Journal of Vertebrate Paleontology* 22(3, Supplement):93A.

- *Программ хангамж, газрын зураг, вебсайт, онлайн хэвлэгдсэн өгүүлэл*

Swofford, D. A. 2003. PAUP* 4.0. Sinauer Associates, Sunderland, Massachusetts.

Izett, G. A., and J. G. Honey. 1995. Geologic map of the Irish Flats NE Quadrangle, Meade County, Kansas, U.S. 1:24,000. U. S. Geological Survey. Geological Survey Miscellaneous Investigations Series Map I- 2498.

Scotese, C. R. Plate tectonic maps and continental drift animations: Late Permian. Paleomap Project, Department of Geology, University of Texas at Arlington. Available at www.scotese.com. Accessed November 8, 2004.

Janvier, P. 1997. Craniata. Tree of Life Web Project. Available at www.tolweb.org/Craniata/14826. Accessed November 30, 2006.

Хүснэгт

Бичвэрт орсон хүснэгтийн тайлбарын эхэнд “TABLE” гэж томоор бичих ба зай аваад дугаарыг бичнэ. Хүснэгтүүд нь үндсэн бичвэрт заавал эшлэгдсэн байна. Хүснэгт нь гарчиг болон тайлбартай байна. Тайлбарт хүснэгтэд агуулгын тайлбарыг дэлгэрүүлэн бичнэ. Хүснэгтэд орсон, өмнө нь хэвлэгдсэн мэдээллийг заавал эшилнэ.

TABLE 2. This is the caption of the table.

Зураг, график

Бичвэрт орсон зураг болон графикийн тайлбарын эхэнд “FIGURE” гэж томоор бичих ба зай аваад дугаарыг бичнэ. Жишээлбэл:

FIGURE 5. Theropod skull bones in lateral view. **A**, dentary of *Allosaurus fragilis* (after Madsen, 1976); **B**, maxilla of same; **C**, dentary of *Carcharodontosaurus*, AMNH 1956. **Abbreviations:** **a**, articular; **af**, ascending facet; **rt**, recurved teeth. Scale bar equals 5 cm.

Хавсралт

Хавсралтууд нь ашигласан материалуудын дараа бичигдэх ба нийт 4 хуудаснаас илүүгүй байна. Хэт дэлгэрэнгүй мэдээллийг (төрөл зүйлийн жагсаалт, морфологи шинжүүдийн жагсаалт гэх мэт) нэмэлт мэдээллийн файл тусад нь үүсгэнэ. Хавсралтын мэдээллүүд нь 2 мөрний зайтай бичигдэнэ. Хавсралтыг бичвэрт дурьдах ба хавсралтыг араб тоогоор 1-ээс эхлэн дугаарлана.

Нэмэлт мэдээлэл

Нэмэлт мэдээлэл нь бичвэрээс тусдаа файл байдлаар байх бөгөөд хэвлэгдэж буй бичвэртэй хамт хэвлэгдэхгүй. Нэмэлт мэдээллийг нь үндсэн бичвэртэй төстэй байдлаар форматлана. Нэмэлт мэдээлэлд үндсэн бичвэрийн гарчиг, зохиогчид, сэтгүүлийн нэр зэргийг бичнэ. Нэмэлт мэдээллийн хүснэгт, зураг, хавсралт нь Table S1, S2; Figure S1, S2; Appendix S1, S2 гэх мэтээр дугаарлана. Нэмэлт мэдээллийг бичвэрт “Supplementar y Data

1” гэх мэтээр эшилнэ. Нэмэлт мэдээлэл агуулсан тусдаа файлд “supplementary_data_1.doc” гэсэн нэр өгч хадгална.

Өгүүллийн формат

Бичвэрийн хуудасны дээд болон доод талд тэмдэглэл (header, footer) ашиглахгүй. Бичвэрийн хуудасны баруун доод талд араб тоогоор дугаарлана. Бичвэрт 3-аас дээш тооны дэд гарчиг ашиглахгүй.

Загвар

Гарчиг болон ерөнхий мэдээллийг шинэ хуудсанд бичнэ. Хураангуй дараагийн нүүрнээс эхэлнэ.

Paleoenvironmental reconstruction of early Cretaceous dinosaur-bearing Ulaanoosh Formation, southern Mongolia

Dorj Bold, *,1,2

Bolor Tuya, ²

Sandag Bat,³

¹ Department of Paleozoology, Institute of Paleontology, Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar-211213, Mongolia, dorj@mas.ac.mn;

² School of Geology and Mining, Mongolian University of Science and Technology, Ulaanbaatar-14191, Mongolia;

³ School of Natural Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar-154234, Mongolia

ABSTRACT (ХУРААНГУЙ)

Хураангуйг шинэ хуудсанд, догол мөр гаргахгүй үргэлжлүүлэн, 11pt-ийн өндөртэй Arial фонт ашиглан бичнэ. Хураангуйг 200 үгэнд багтаана. Хураангуйд эшлэл, хүснэгт, зураг, дэд гарчиг, үгсийн товчлол зэргийг оруулахгүй.

KEYWORDS (ТҮЛХҮҮР ҮГ)

Түлхүүр үгс нь хураангуйтай хамт ижил хуудсанд бичигдэнэ. Түлхүүр үгсийг 8-аас хэтрүүлэхгүй бичнэ.

PRIMARY HEADING (БҮЛГИЙН ГАРЧИГ)

Текст болон дэд гарчгийг бүлгийн гарчгаас нэг хоосон мөр авч бичнэ. Текстийг догол мөр авч бичнэ. Бүлгийн гарчгийг том үсгээр бичнэ.

Secondary Heading (Бүлгийн Дэд Гарчиг)

Текстийг догол мөр авч бичнэ. Бүлгийн дэд гарчгийн үгний эхний үсгүүдийг томоор бичнэ. Бүлгийн гарчигт зураг, хүснэгтийг эшлэхгүй.

Tertiary Heading (Бүлгийн Гуравдагч Гарчиг)- Текстийг бичихдээ гарчгийн хойно зураас (-) татаж бичнэ. Гуравдагч гарчгийг догол мөрнөөс эхлэн бичнэ. Гарчгийн эхний үсгүүдийг томоор бичнэ. Бүлгийн гарчигт зураг, хүснэгтийг эшлэхгүй.

Товчлол

Байгууллагын нэр болон анатомийн нэрийн товчлолыг гуравдагч гарчиг байдлаар бичнэ. Товчлолыг цагаан толгойн дагуу жагсаана. Товчилсон нэрийг тодоор бичих ба таслалыг тодруулахгүй. Жишээлбэл:

Institutional Abbreviations—**AMNH**, American Museum of Natural History, New York; **MCZ**, Museum of Comparative Zoology, Harvard University.

Anatomical Abbreviations—**a**, articular; **prz**, prezygapophysis; **z**, zygantum.

ACKNOWLEDGMENTS (Талархал)

Талархалд хүмүүс, грант, сангийн нэрийг бүтнээр бичнэ.